



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр

АГУУЛГА

Нэг. Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ ажлын товч тайлан

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн журмын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлсэн тайлангуудын жагсаалт:

- 1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*
- 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн хөгжлийн яаманд цахимаар тайлагнасан.*
- 3. Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн хөгжлийн яаманд цахимаар тайлагнасан.*
- 4. Шинэ сэргэлтийн бодлогын 2023 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Эдийн засгийн хөгжлийн яаманд цахимаар тайлагнасан.*
- 5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*
- 6. Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2024.02.28-ний өдрийн 01/854 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.*
- 7. Шилэн дансны хөтлөлтийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар үнэлж, 2023.01.25-ны өдрийн 10/361 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.*
- 8. ЗТХЯ-ны 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, ХШҮ-ний тайлангийн хамт ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*
- 9. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*
- 10. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*
- 11. Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгуудын Засаг дарга нарын 2023 оны хамтын ажиллагааны гэрээ, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2024.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид яам гэх/-ны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

Тайлант хугацаанд яамны 2023 оны үйл ажиллагааг Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, 2023 оны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зам, тээврийн салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ зэрэг 8 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргав.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнаж ажилласан. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл,

Засгийн газрын албан даалгавар зэрэг 10 үзүүлэлтээр нийт 104 шийдвэрийн 190 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд бүрэн хэрэгжсэн 129, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 37, хэрэгжилт хангалтгүй 30 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ, хугацаа болоогүй 21 арга хэмжээний дундаж үнэлгээ **92.2** хувиар үнэлэгдлээ. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл:

/Хүснэгт 1/

№	Үйл ажиллагааны чиглэл	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	Хяналтаас хасагдсан	Биелэлт хувь
			100	70	30	0				
1	Нийт	190	129	37	3	-	21	-	-	92.2

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.2. МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Засгийн газрын 2021 оны 203 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 95 арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ. Төлөвлөгөөний хэрэгжилтийн дунджаар **70.4** хувьтай байна.

Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх нэгжүүдийн үнэлгээг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 2/

№	Нэгжийн нэр	Арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/						Хугацаа болоогүй	Санхүүжилт -гүй	ХШҮ хувь
			100	90	70	50	30	0			
1	АЗБЗГ	59	20	4	9	0	12	1	2	11	72.8
2	АТБЗГ	5	2	0	1	1	1	0	0	0	70.0
3	ТЗДТБЗГ	13	5	1	0	4	3	0	0	0	67.7
4	БТГ	2	1	0	1	0	0	0	0	0	85.0
5	ТЗУГ	1	1	0	0	0	0	0	0	0	100.0
6	ИНБЗГ	15	3	1	4	0	6	0	0	1	60.7
Нийт		95	32	6	15	5	22	1	2	12	70.4

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 0-30 хүртэл хувийн биелэлттэй 23 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

- Дорноговь аймгийн Сайншанд - Баруун-Урт - Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ;
- Улаанбаатар төмөр замын гол замд 200 км их засвар хийнэ;

- Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төсөл;
- Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ;
- Налайх- Төв аймгийн Баян сум чиглэлийн 58 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ;
- Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барина;
- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Овоотын уурхайгаас Арцсуурь хилийн боомт хүртэлх авто замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна;
- Өмнөговь аймгийн Ханхонгор сумын ТавантолгойБарууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барина;
- Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замыг барина;
- Баянхонгор аймгийн төвөөс Шаргалжуут чиглэлийн 54.17 км хатуу хучилттай авто замын төслийг эхлүүлнэ;
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Арбулаг чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг барина;
- Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хучилттай авто замыг барих /Ховд, Увс аймаг/;
- Завхан аймгийн Улиастай сумын Богд Чигэстэйн голын 290.03 у/м төмөр бетон гүүрийг барина;
- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Онгийн голын 166 у/м төмөр бетон гүүр;
- Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхоны голын 290 у/м төмөр бетон гүүр;
- Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Гашуунсухайт боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулна;
- Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Завхан голын төмөр бетон гүүр;
- Агаарын навигацын үйлчилгээний техник технологийг шинэчилнэ;
- Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;
- Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;
- Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;
- Увс аймгийн "Дэглий цагаан" нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ;
- Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засвар.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.3. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг баталсан. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан 3 зорилтыг хэрэгжүүлэх нийт 25 арга хэмжээ байна. Үүнд:

- Авто замын салбарт хэрэгжүүлэх 20 арга хэмжээ;
- Төмөр зам, далайн тээврийн салбарт хэрэгжүүлэх 3 арга хэмжээ;
- Автотээврийн салбарт хэрэгжүүлэх 2 арга хэмжээ;

Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 25 арга хэмжээний хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл дунджаар **72.8** хувийн биелэлттэй үнэлэгдлээ. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх нэгжүүдийн үнэлгээг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 3/

№	Нэгжийн нэр	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/						Хэрэгжилт хувь
			100	90	70	50	30	0	
1	Авто замын бодлого зохицуулалтын газар	20	4	4	8	2	2	-	74.0
2	Автотээврийн бодлого зохицуулалтын газар	2	1	1	-	-	-	-	95.0
3	Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар	3	-	-	-	3	-	-	50.0
Нийт		25	5	5	8	5	2	-	72.8

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 30-50 хүртэл хувийн биелэлттэй 7 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

- 2.2.2.5. Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын барилга /хэрэгжилт 50 хувь/;
- 2.2.2.7. Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах /хэрэгжилт 50 хувь/;
- 2.2.2.8. Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах /хэрэгжилт 50 хувь/;
- 2.2.2.9. Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах /хэрэгжилт 50 хувь/;
- 2.6.4. Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр зогсох цэгийг 100 км тутамд барьж байгуулах /хэрэгжилт 30 хувь/;
- 5.2.2.11. Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто замын барилга /хэрэгжилт 30 хувь/;
- 5.2.2.12. Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай 56.9 км авто замын барилга /хэрэгжилт 50 хувь/.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.4. Зам, тээврийн салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ:

Зам, тээврийн хөгжлийн салбарын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар үнэлэхэд 16 үзүүлэлтийн 35 заалтаас 10



үзүүлэлт, 26 заалт нь 100 болон түүнээс дээш хувиар биелсэн ба зорилтот түвшин хүрээгүй 0 хувиар үнэлэгдсэн 2 заалт байна.

Зорилтот түвшингээс давуулан биелсэн үзүүлэлтүүдийг 100 хувь гэж дүгнэвэл Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилт дунджаар **86.5** хувийн биелэлттэй байна. Энэ нь 2022 оноос 6.1 хувиар хэрэгжилт буурсан байна.

/Хүснэгт 4/

№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Суурь үзүүлэлт /2022 он/	2023 он			ХШҮ
				Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Хувь	
1	Тээвэрлэсэн ачаа (мян.тонн)	Автотээвэр	33,075.6	25,045.30	71,254.90	284.50%	100
		Төмөр замын тээвэр	27,680.9	30,627.90	36,114.20	117.91%	100
		Агаарын тээвэр	12.9	3	8.57	285.67%	100
2	Дамжин өнгөрөх (транзит) ачаа (мян.тонн)	Төмөр замын тээвэр	3,174.5	4,144.40	5,094.40	122.92%	100
3	Ачаа эргэлт (сая тонн/ км)	Автотээвэр	2,591.9	4,186.80	10,619.10	253.63%	100
		Төмөр замын тээвэр	14,948.8	19,243.80	18,869.30	98.05%	100
		Агаарын тээвэр	32	10.7	24.3	227.10%	100
4	Зорчигчдын тоо (сая.хүн)	Автотээвэр	143	143.6	142.6	99.30%	100
		Төмөр замын тээвэр	2.4	2109.8	2,141.8	101.52%	100
		Усан замын тээвэр	0.04	32.8	64.7	197.26%	100
		Агаарын тээвэр	0.9	594.3	1,731.3	291.32%	100
5	Зорчигч эргэлт (сая хүн/ км)	Автотээвэр	1,914.9	2,294.00	1,813.2	79.04%	70
		Төмөр замын тээвэр	703.4	618.6	797.5	128.92%	100
		Агаарын тээвэр	1,828.4	856	3,880.8	453.36%	100
6	Тээвэрлэлтийн орлого (тэрбум төгрөг)	Автотээвэр	784.6	578	4,676.4	809.07%	100
		Төмөр замын тээвэр	747.2	788.7	1,125.0	142.64%	100
		Агаарын тээвэр	505.2	187.4	941.9	502.61%	100
7	Зам, тээврийн салбарт шинээр нэвтрүүлсэн техник, технологийн тоо	Зам, тээвэр	4	-	3	-	0
8	Нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон аймгийн төвийн тоо	Авто зам	21	21	21	100.00%	100

9	Олон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээний урт (өссөн дүнгээр) (км)	Авто зам	7,833.5	7,345.80	7,535.60	102.58%	100
10	Шинээр ашиглалтад оруулах замын урт (км)	Авто зам	483.33	654.15	381.4	58.30%	50
		Төмөр зам	286.9	-	286.9	-	0
11	Шинээр ашиглалтад орсон гүүрийн урт (м)	Авто зам	500.24	218.36	841.87	385.54%	100
12	Тээврийн чиглэлийн тоо	Автотээвэр	45	246	215	87.40%	90
		Олон улсын нислэг	24	37	43	116.22%	100
13	Буулт, хөөрөлтийн тоо (мян.)	Агаарын тээвэр	14.15	9.3	19.96	214.67%	100
14	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо (мян.)	Агаарын тээвэр	37.56	85.8	43.5	50.70%	50
15	Тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт	Автобус	626	150	279	186.00%	100
		Зүтгүүр	177	162	190	117.28%	100
		Ачааны вагон	12,440	6,648	6,874	103.40%	100
		Зорчигчийн вагон	309	260	321	123.46%	100
		Агаарын хөлөг	25	38	60	157.89%	100
16	Вокзал буудлын тоо (өссөн дүнгээр)	Автовокзал	25	28	25	89.29%	90
		Төмөр замын буудлын тоо	79	76	70	92.11%	90
		Нисэх буудлын тоо	26	26	25	96.15%	90

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.5. Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 141 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 72 арга хэмжээ, 90 хувийн 23, 70 хувийн 26, 50 хувийн 13, 30 хувийн 4, үнэлгээнд тооцоогүй 3 арга хэмжээний хэрэгжилт **85.9** хувь байна. Үүнээс хариуцсан нэгж, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээр нь авч үзвэл:

/Хүснэгт 5/

№	Нэгж	Нийт	Үнэлгээ /хувиар/	ХШҮ
---	------	------	------------------	-----

			100	90	70	50	30	0	Үнэлгээнд тооцоогүй	
1	БТГ	15	7	2	4	1	1	-	-	82.6
2	ТЗУГ	25	21	3	1	-	-	-		97.6
3	АЗБХЗГ	35	14	10	5	5	-	-	1	85.3
4	ИНБХЗГ	14	8	2	2	1	-	-	1	90.0
5	АТБХЗГ	15	5	3	3	2	1	-	1	79.3
6	ТЗДТБХЗГ	28	8	3	11	4	2	-	-	75.0
7	ХШУДАГ	5	5	-	-	-	-	-	-	100.0
8	СХГ	4	4	-	-	-	-	-	-	100.0
Нийт		141	72	23	26	13	4	-	3	85.9

Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 3 арга хэмжээ зорилтод түвшинд хүрэх боломжгүй болсон тул үнэлгээнд оруулж тооцоогүй. Эдгээрийг дурдвал:

- Арга хэмжээ 4.10. “Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг эхлүүлнэ” /АЗБХЗГ, 1-4 улирал, Нутгийн ард иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, барилгын ажил эхлүүлэх боломжгүй болсон/;

- Арга хэмжээ 5.7. “Агаарын зайн зохион байгуулалтыг сайжруулж, агаарын замыг шинэчлэн тогтоох” /ИНБЗГ, 3-4 улирал, Төрийн өндөр дээд хэмжээний айлчлал болон Зам, тээврийн хөгжлийн Сайд БНХАУ-д хийсэн албан томилолтын үер агаарын шинэ хаалга нээх асуудлаар санал солилцсон ба 2023 онд шинээр агаарын хаалга нээх асуудал БНХАУ-аас хариу мэдэгдэл ирүүлээгүй тул тус арга хэмжээ хэрэгжих боломжгүй байна/;

- Арга хэмжээ 8.2. “Автотээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулах” /АТБЗГ, 1-2 улирал, УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Автотээврийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэх боломжгүй болсон/.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ байна. Үүнд:

- Арга хэмжээ 2.7. “Сайншанд-Зүүнбаян чиглэлийн зам, Сайншанд Зүүнбаян өртөөдийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлэх” /ТЗДТБЗГ, 2-4 улирал/

- Арга хэмжээ 2.9. “Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын эхлэлийн Шивээхүрэн Нарийн сухайт чиглэлийн төмөр замыг эхлүүлэх” /ТЗДТБЗГ, 2-4 улирал/

- Арга хэмжээ 9.13. “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах” /АТБЗГ, 1-4 улирал/

- Арга хэмжээ 10.5. “Үнэмлэх, гэрчилгээ, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод нээлттэйгээр бүрэн цахимжуулах.” /БТГ, 2-4 улирал/;

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу ЗТХЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.6. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт:

“Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/88 дугаар тушаалаар баталсан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хүснэгтийн дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны биелэлтийг тайлагнахад 7 зорилтын 26 арга хэмжээний хэрэгжилт **98.5** хувьтай үнэлэгдлээ. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлвэл:

/Хүснэгт 6/

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх		
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах		
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	100
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	90
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	100

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.7. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авилгаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох, хангах талаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас хийж буй ажлын явцад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтийн 5 хэсгийн 46 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **98.5** хувь байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 7/

Хэсэг	Нийт Арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/					Хугацаа болоогүй	Чиг үүрэгт хамаарахгүй	ХШҮ
		100	70	30	0				
1	10	8	1	-	-	1	-	96.6	
2	6	5	-	-	-	1	-	100.0	
3	15	15	-	-	-	-	-	100.0	
4	2	2	-	-	-	-	-	100.0	
5	13	7	1	-	-	3	2	96.2	
Нийт	46	37	2	-	-	5	2	98.5	

Харьяа байгууллагуудын нийтийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг улирал бүр хяналтад авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар харьяа байгууллагын нэгдсэн дүнг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 8/

№	Харьяа байгууллага нэр	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Чиг үүрэгт хамаарахгүй	ХШҮ
			100	70	30	0		
1	АТҮТ	46	27	3	2	4	10	82.5
2	ЗТХТ	46	22	2	2	7	13	72.7
3	ИНЕГ	46	32	3	-	5	6	85.2
4	НТОЗШША	46	9		2	1	34	80.0
5	МИАТ	46	28	1	2	2	13	88.8
6	ХХНОБ	46	13	4			29	92.9
7	ГТХЗНТ	46	25	5	1	-	15	92.9
8	ДЗ	46	23	1		4	18	84.6
9	МТЗ	46	34	4		2	6	92.0
10	УБТЗ	46	15	1	2	6	22	67.9
11	ТТЗ	46	30	3	3	3	7	84.6
Нийт	506	258	27	14	34	173	94.0	

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.

2.8. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн нэгдсэн тайлангийн хэрэгжилт:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрийн 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмыг үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулга, стандартын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас аудит хийж ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 89 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2023 оны 4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийв. Үүнд:

- Улсын төсвийн байгууллага 3
- Төсөл, арга хэмжээ 4
- Төрийн өмчит аж ахуй нэгж 80
- Хувь нийлүүлсэн нийгэмлэг 1
- Төрийн өмчит ХХК 1 гэсэн нийт 89 төрийн байгууллага, хуулийн этгээд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 89 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд салбарын хэмжээнд 13,591 мэдээлэл байршуулахаас мэдээллэсэн 13,388, үүнээс хугацаа хоцроосон 192, мэдээлэл оруулаагүй 203, гүйцэтгэл **96.0** хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2023 оны тайланг 2024.1.25-ны өдрийн 10/361 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

ГУРАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

3.1. Тайлант хугацаанд яамны 2023 оны үйл ажиллагааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Зам, тээврийн салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, Аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичиг, гэрээ, Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт, яамны нэгж, харьяа байгууллагуудын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримт, төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврууд зэрэг 17 үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жил, бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 124 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан.

3.2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасан тайлангуудыг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг байгууллагуудаас нэгтгэн авч хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт журамд заасан хугацаанд тухай бүр ЗГХХГ, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааг улирал хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэх үзүүлэлт болгон ашигласан.

3.3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны үйл ажиллагааг дүгнэвэл:

/Хүснэгт 9/

1	Үзүүлэлт	Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	92.2	0.6	2.41
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	70.4		
	3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	72.8		
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	86.5		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	85.9	0.2	0.92
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	98.5		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	98.5	0.2	0.97
	2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	96.0		
	3. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		86.2	1.0	4.3

Шударга байдлын үнэлгээг АТГ-аас гаргадаг, Хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар үнэлдэг болно.

Ерөнхий үнэлгээ хийсэн аргачлал:

$$\Sigma = 0.05 * [(92.2 + 70.4 + 72.8 + 86.5) \div 4 * 0.6 + (85.9 + 98.5) \div 2 * 0.2 + (98.5 + 96.0) \div 2 * 0.2] = 0,05(48.28 + 18.44 + 19.45) = 4.3$$

ДӨРӨВ. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

4.1. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан боловч бүрэн хэрэгжээгүй арга хэмжээ болон ЗГҮАХ, Шинэ сэргэлт, Улсын хөгжлийн төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврууд, бусад төлөвлөгөөнд туссан ч хэрэгжилт хангалтгүй байгаа бусад арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны эхнээс хяналт тавьж, ажиллахыг яамны нийт албан хаагч нарт;

4.2. Зам, тээврийн салбарын хуулиудын батлагдсантай холбогдуулан эдгээр хуулиудтай уялдуулан салбарын эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар болон бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;

4.3. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа арга хэмжээнүүдийн талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлуудыг яаралтай дуусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар, болон бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;

4.4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсонтой холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн батлуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт;

4.5. Холбогдох тайлан, мэдээллийг тодорхой тоо баримт, огноотой, товч тодорхой бичиж, хийсэн ажлаа бүрэн тайлагнаж, журамд заасан хугацаанд ирүүлж байхад яамны нийт ажилтнууд анхаарч ажиллахыг тус тус зөвлөж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ.